

**Зохиогч нь тодорхойгүй “Дөрвөн Ойрадын түүх тууж”  
зохиолын тухайд**

Докторант На.Сүхбаатар /УБИС/

Монголын түүхийн сурвалж бичгүүдийн дотор тод үсгээр бичигдэж бидний үед хүрэлцэн ирсэн хэд хэдэн түүхийн сурвалж зохиолууд бий. Эдгээрийн дотроос зохиогч нь тодорхойгүй “Дөрвөн Ойрадын түүх тууж” хэмээх сурвалж нь түүх бичлэгийн талаар болон өгүүлэгдэх мэдээний агуулга, хувилбар эхүүдийн адил болон зөрүүтэй хэсэг, олдсон газар нутаг, зохиогдсон цаг хугацаа, зохиогч зэрэг хэд хэдэн зүйлээр анхаарал татахуйц сонирхолтой сурвалж юм.

“Дөрвөн Ойрадын түүх тууж” зохиол Ховдын хязгаарт зохиогдож тархсан нь бусад тод үсгийн түүхийн сурвалжуудаас ялгагдах нэг онцлог юм. Тод үсгээр бичигдсэн түүхийн дийлэнхи сурвалж зохиолууд Зүүнгарын хаант улсын үед болон хожим Халимагийн ойрадууд, Или, Эрчис, Хөх нуурын ойрадуудын дунд зохиогдсон байдаг. Габан Шаравын “Дөрвөн Ойрадын түүх”, Баатар увашийн “Дөрвөн Ойрадын түүх” зохиолууд Халимагт зохиогдсон бол “Хо өрлөгийн түүх”, “Монголын уг эхийн түүх”, “Богд Чингисийн уг, Дөрвөн Ойрадын уг, Хошуудын угийн түүх бичиг”, “Торгууд хаадын түүх” зэрэг сурвалж зохиолууд Шинжаанд зохиогдож тэндээ тархсан, үндсэн эхүүд нь мөн тэндээ хадгалагдаж байна.

“Дөрвөн Ойрадын түүх тууж” зохиолын өдгөө мэдэгдэж байгаа гурван эх бүгд Монгол улсын нутгаас, тэр тусмаа Ховд, Увс аймгаас олдсон бөгөөд тэдгээр нь ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн болон УТНС-д хадгалагдаж байна.

Зохиолын эхүүдийн тухай.

Тус зохиолын 3 янзын эх байна.

Нэг дэх нь ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн сан хөмрөгт 853/1/ дугаар хадгалагдаж байгаа харьцангуй сайн тод гаргацтай “Дөрвөн Ойрадын түүх тууж” [1.] нэртэй эх юм. Хэмжээний хувьд 30 хуудас, нийт 60 тал.

Хоёр дахь нь мөн тус сан хөмрөгт 1071 дугаартай хадгалагдаж байгаа “Дөрвөн Ойрадын намтар” [2.] нэртэй хувилбар эх юм. Энэ эх нэг дэх эхээс зарим нэг илүү мэдээ агуулснаараа ялгагдах боловч хадгалагдсан байдлаараа нэг дэх эхэд арай хүрэхгүй байна.

Гурав дахь нь УТНС-д хадгалагдаж байгаа “Дөрвөн Ойрадын намтар түүх” [3.] нэртэй эх юм. Нийт хэмжээ 76 хуудас.

Эдгээр эхүүдийн аль нэгийг анхдагч, үндсэн эх гэж тодорхойлох боломжгүй байна. Бүгдээрээ хулсан үзгээр хуулж бичсэн, бичиж салгахдаа үг үсгийн алдаа ихтэй, жишээлбэл “Хошууд Нагчихбуг хавтгай сарын хорин тавдугаар үеийн ач хэмээсний...” [Дөрвөн Ойрадын...,1976,&12a] гэдэгт Хавт Хасар гэдэг үгийг хавтгай сар хэмээн бичжээ. Мөн үг орхигдуулсан зэрэг дутагдал их бий. Энэхүү 3 эхэд үндсэн эхийн шинж байхгүй тул бид тэдгээрийг хувилбар эхүүд гэж тооцлоо.

Судлагдсан байдлын тухай

Анх 1960 онд эрдэмтэн Х.Пэрлээ “Хувьсгалаас өмнөх үеийн Монголын түүх бичлэгийн асуудалд” бүтээлдээ тус зохиолын тухай товч дурджээ. Гэхдээ УТНС-д буй “Дөрвөн Ойрадын намтар түүх” гэсэн хувилбарыг авч үзээд, “Үүнийг 1751 оны үед зохиосон бололтой, зохиогчийн нэр мэдэгдээгүй. Энэ зохиолын нэр нь орон нутгийн түүх шинжтэй боловч, дотор нь бичсэн гол үнэтэй сонин хэрэг явдал нь Ар, Өвөр монголд холбогдох 17-18 дугаар зууны үеийн мэдээнүүд юм. Дөрвөд, Ойрадад холбогдох зүйл гэвэл, Амарсанаагийн тухай домоглол бий” [Пэрлээ.1960.т. 21] гэсэн товч тэмдэглэл үйлджээ. Х.Пэрлээ абугайн энэ тэмдэглэл зарим талаар ташаарчээ. Тэрбээр зохиолыг гүймэгхэн үзсэн нь илт байна. Тус зохиолд Ар, Өвөр Монголын тухай мэдээ бараг байхгүй, харин Ойрадын Зүүнгар, Дөрвөдийн түүхэнд зориулагдсан нь зохиолын агуулгаас шууд мэдэгдэнэ.

1976 онд эрдэмтэн Х.Лувсанбалдан “Тод үсгийн дурсгалууд” бүтээлдээ тус сурвалжийн 3 эхийг харьцуулан харилцан нөхвөрлөж, шинэ эх үүсгэснээ латин галигаар хэвлүүлж олны хүртээл болгосон билээ. Мөн товч оршил бичиж, зохиолын зохиогдсон он, аль үед хамаарах тухай Х.Пэрлээ гуайн саналыг дэмжсэн байна [Тод үсгийн...,1976.т.12]. Латин галигаар хэвлүүлэхдээ 853/1/ дугаар бүхий эхийг гэрэл зургийн аргаар хавсарган хэвлүүлсэн нь уг сурвалжийг судалгааны эргэлтэнд орох эхлэлийг тавьсан байна.

1985 онд Өвөр Монголын эрдэмтэн Бадай, Эрдэнэ, Алтан-Оргил нар “Ойрад түүхэн сурвалж бичиг” эмхтгэлдээ тус сурвалжийг Х.Лувсанбалданы латин галигаас монгол бичигт буулгаж, зарим үг, утга санаанд тайлбар хийж хэвлүүлсэн юм. [Ойрад түүхэн...,1985.т.265-305].

2001 онд миний бие дээрх эхүүдийг тулган нягталж, Х.Лувсанбалданы латин галигийг гол болгон кирилл бичигт буулгаж, 853/1/ дугаартай эхийн хамт товч оршил, зарим тайлбартайгаар хэвлүүлжээ [Ойрад Монголын...,2001.т.19-81].

“Дөрвөн Ойрадын түүх тууж” сурвалжид гардаг мэдээ мэдээллийг бусад түүхийн сурвалжийн мэдээтэй харьцуулан судалсан судалгаа бараг хийгдсэнгүй. Холбогдох судалгааны бүтээлд тус сурвалжаас эшилсэн нь бага, ихэнх тохиолдолд дам эшилж байгаа нь тус зохиолыг эх сурвалж болох, үнэт мэдээлэл агуулсан гэдгийг нь нээн харуулж чадаагүйтэй холбоотой ажээ.

Тус сурвалжийн зохиогдсон он, цаг хугацааны тухай.

Х.Пэрлээ аругай тус зохиолын зохиогдсон оныг “1751 он бололтой” [Пэрлээ.1960.т.21] гэсэн таамаглал хийжээ. Түүний 1751 он гэж тэмдэглэсэн нь түүх судлалын суурь бүтээлд туссан байдаг [БНМАУ-ын...,1968.т.14].

1753-1759 оны хооронд дахь Дөрвөдүүдийн нүүдэл, Улаангомын газар суусан, 1755 онд Зүүнгарын эсрэг Манж Чин улсын хийсэн дайн, Амарсанаа Оросот оргон одсон тухай, Торгуудын Шэрэн тайж 1771 онд Халимагаас Алтай нутагтаа буцаж ирсэн тухай мэдээг багтаасан учир 1770-аад оны үед зохиогдсон гэлтэй байна.

Зохиолд түүхэнд он цаг нь тодорхой болсон зарим түүхэн хэрэг явдлын тухай “Торгууд хошуудын бум долоон мянган өрх улс Оросод оров. Торгууд Шэрэн тайж, таван хошуу Бэш шагаштай хамт Ховдод орж ирэв. Бэш Шагаш үхэв. Албат нь хариу нүүв” [Дөрвөн Ойрадын...,1976,&29b] хэмээн мэдээлсэн нь цаг хугацааны хувьд хамгийн сүүлийн мэдээ байна. Энэ нь уг зохиолыг 1771 оноос хойно зохиосон гэж үзэхэд хүргэж байна. Гэхдээ тус сурвалж бичлэгийн хувьд он дарааллаар бичигдсэн эхлэл төгсгөл бүхий түүх бус, хэсэг бусад мэдээг нэгтгэн эмхтгэсэн шинжтэй гэдгийг харгалзах хэрэгтэй.

Зохиогчийн тухай.

Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн сан хөмрөгт буй эхүүд 1950-иад оноос өрнөсөн хуучин ховор судар номуудыг цуглуулах, хамгаалалтанд авах ажлын хүрээнд Ховд, Увс аймаг буюу Ховдын хязгаараас олджээ. Бидний авч үзэж буй дээрх 3 эхээс өөр хувилбар эх хараахан олдоогүй тул зохиогдсон газар нь Монголын баруун хязгаар нутаг гэдэг тодорхой байна.

Сурвалжийг зохиогч Дөрвөд аймгийн, бүр нарийвчлан үзвэл Баядын Цэрэнмөнхийн харъяат лам хүн байсан бололтой. Учир нь зохиолд “Баядын Цэрэнмөнхийн ахмад хүү Чимэг харавч (харваач-На.С) сайн бөгөөд Даваач ноёны өргөөнд нас барсан” [Дөрвөн Ойрадын...,1976,&13b] “Цэрэнмөнх найман настай хөвгүүн Цэвэг, долоон настай хөвгүүн Бабул хоёр ачаа авч буцав” [Дөрвөн Ойрадын...,1976,&14a] болон Баядын Абу буучтай холбогдох мэдээнүүд, Баядын Батмөнх хэмээх чадал ихтэй залуугийн тухай, Батмөнх нь Амарсанаагийн сайн анд болсон тухай зэрэг Баядын түүхэнд холбоотой нарийн мэдээнүүдийг дурдсан байна.

Мөн зохиогч 1750-иад оны үйл явдлуудад биеэр оролцсон нь илэрхий байна. Тэрбээр 1750 оноос хойшхи үйл явдлуудыг "...Хаан, Даш ноёныг зээ цуглана гэж оров. Даш ноён ирэв, өшөөрхөж, Даш ноёныг нь хороов. Дөрвөд бас хийд олов. Хаан ширээ салшгүй болов. Амарсанаа ширээ булаалдан дайн болов. Хаанаас цэрэг морд хэмээн

зар ирэв. Дөрвөд чуулган чуулав. Зарим нь цэрэг мордоё гэв. Баяд ноён Абу зарлиг болов, энэ ер талаар, манжийн хаанд ороё гэв. Бүгдээр зөв гээд өдөр шөнөгүй нүүв. Халх зулж өмөөр оров. Түүнийг Улистайн (Улиастай-На.С) Уу жанжин сонсоод элч явуулж, Дөрвөд Түйн голд гүйцэж зогсоов" [Дөрвөн Ойрадын...,1976,&25a], "Дөрвөдөд Улаангом шагнав. Тэнгэр тэтгэгч хааны арван наймдугаар он (1753-На.С)-д орсон, тахиа нохой жил (1753,1754-На.С)-д Хангай нутагласан, гахай жил (1755-На.С)-д Шадар вангийг халх мэхэлж нүүлгэхэд, дөрвөд тайж орон Улаангомд байлгаж болохгүй гэж У жанжин хивэс ирэв хэмээн, таныг Алтайдаа гартун гэнэ гэв. Дөрвөд баярлан өдөр шөнө дүлин нүүвэй. Ирэх нь Алтай нь гомдсондоо өвс ус таг хатсан байжээ. Тэр жил цөм зутав" [Дөрвөн Ойрадын...,1976,&26a] гэх мэтээр үйл явдлыг товч боловч тодорхой тоочиж бичжээ.

Тэрбээр зохиолын эхний хэсэгт буй шашин дэлгэрсэн түүх, бурхны шашны ном судар уншихыг зөвлөсөн болон "Манай дацан туулай жилд (1747-На.С) тогтсон бөгөөд нэг зуун хорьдогч туулай жилийн бага мөчлөгийг хичээж өнгөрүүлэв" [Дөрвөн Ойрадын...,1976,&11a] хэмээн өгүүлсэн нь зохиогчийн шашны боловсролтой, лам хүн гэдгийг илтгэж байна.

#### Зохиолыг бичихэд ашигласан үндсэн сурвалжууд

Зохиогч зохиолоо бичихдээ бичгийн сурвалж болон аман мэдээг өргөн ашиглажээ. Бичгийн сурвалжууд ашигласнаа "Саран гэрэл хэмээх тууж" [Дөрвөн Ойрадын...,1976,&7b], "Их дэлгэр түүх" "Их үлгэрийн далай хэмээх далан хоёр хан хөвгүүний тууж", "Богд Бигэрмижид хааны арван хоёр боть" [Дөрвөн Ойрадын...,1976,&8a], "Чингисийн намтар" [Дөрвөн Ойрадын...,1976,&12a] гэж дурджээ. Энд дурдсан "Их дэлгэр түүх" зохиол бидний үед хүрэлцэн ирээгүй бөгөөд агуулга нь дөрвөн Ойрадын эв нэгдлийн тухай өгүүлдэг зохиол байжээ.

Зохиогч тухайн үед тархсан аман түүхийн мэдээг ихээр ашигласан нь илт байдаг. Цаг хугацааны хувьд алслагдсан, нарийн тогтоох боломжгүй түүхэн хэрэг явдлуудыг аман мэдээнд үндэслэж бичжээ. Аман мэдээ зохиолын хэсэг болгонд тохиолдож байна. Энд өгүүлсэн аман мэдээг үндэслэн тухайн үеийн хүмүүсийн түүхийн сэтгэлгээ, цаг үеэ ойлгох чадварыг тогтоох боломжтой юм.

Зохиолд нэлээд хэдэн домог байна. Амарсанаа нэг гартаа чулуу, нөгөө гартаа нөж атгаж төрсөн тухай [Дөрвөн Ойрадын...,1976,&9a], Баядын Батмөнх гэдэг чадалтай сайн эрийн тухай [Дөрвөн Ойрадын...,1976,&14a], Амарсанаа эргэж ирэх тухай [Дөрвөн Ойрадын...,1976, &15a,&15b], Тэмээн хар бөхийн тухай [Дөрвөн Ойрадын...,1976,&18a-19b] зэрэг домгууд байна. Зохиогч энэ домгуудыг зүгээр нэг хэлхэж орхисонгүй, зохиолын агуулгатай нягт холбогдуулан оруулжээ. Тухайлбал, Тэмээн хар бөхийн домгийг Цэвээнравдан хаанд Манжийн элч нар бараалхах үед тэдний бэлэглэсэн нумыг 19 настай хөвгүүн хуга татаж орхисон, элч нар гайхаж сүр алдаад ичсэн [Дөрвөн Ойрадын...,1976, &18b] хэмээн домоглосон байна.

Мөн зохиогч нь түүхэн үйл явдалд биеэр оролцогч тул нүдээр үзсэн үндсэн сурвалж болгон ашиглажээ. Дөрвөдүүдийн нүүдэл, Улаангомд ирээд тарьсан тариа нь үржин ургахлаараа толгойдоо таван салаатай тариа ургасан тухай гэх зэрэг олон мэдээг өгүүлжээ.

#### Зохиолын гол агуулга

Зохиолын ерөнхий бүтэц нь түүхийн мэдээ болон домгийг нягт уялдуулан бараг хэсэг бүхэнд нэр өгч болохуйцаар бүлэглэн бичжээ. Энэ нь уг зохиолыг он дарааллын дагуу бичигдсэн эхлэл төгсгөл бүхий зохиол бус, харин хэсэг бусаг зүйлүүдийг түүвэрлэн авч бичсэн зохиол гэж үзэхэд эрхгүй хүргэнэ.

Зохиолын агуулгыг доорх байдлаар багцалж үзэх боломжтой байна.

1. Дөрвөн зүгийн улсыг шинжихүй.
2. Шашин газар газарт дэлгэрсэн тухай.
3. Зуу адиша хэмээх хувилгаан Ойрадад тодорсныг Тангуд булааж авсан тухай.
4. Ойрадууд хэд хэдэн газар нутагт нүүдэллэж байсан нь.
5. Ойрадын бүтэц бүрэлдхүүн (XVII зууны үеийн)

6. Равжамба Зая бандида ном сурч ирээд, тод үсэг зохиосон тухай.
7. Их дэлгэр түүх, Сарны гэрэл хэмээх сурвалжуудын тухай мэдээ.
8. Хошуудын Хөндлөн увашийн дүрвэсэн тухай.
9. Амарсанаагийн уг гарал, төрсөн тухай.
10. Амарсанаатай холбоотой нэгэн домог.
11. Даваач хаан Манжийг эсэргүүцэхэд бусад нөхөд нь хаяж одсон тухай
12. Ойрадууд хоёр удаа Түвэдэд цэрэглэсэн тухай
13. Ойрадын нэг хэсэг нь дүрвэж, Орос, Түрэг хоёр улсын завсар нутагласан тухай
14. Баядын Батмөнх гэдэг чадалтай сайн эрийн тухай домог
15. Манжийн Саруул жанжин Амарсанааг мөшгисөн нь
16. Амарсанаа эргэж ирэх тухай домог
17. Эртний дөрвөн Ойрадын тухай мэдээ (ХҮ зууны үе)
18. Хасагийн хан Абулайн тухай
19. Тэмээн хар бөхийн тухай домог
20. Ойрадууд Түвэдэд цэрэглэсэн болон улааны шашинтныг дарсан тухай
21. Зүүнгарын хаант улсын цэрэг 1731 онд Халхад довтолсон тухай
22. Манжийн хаан элч илгээсэн тухай
23. Торгуудын Аюуки хааны хүү Санжавын тухай
24. Дөрвөн Ойрадын бүтэц бүрэлдэхүүн (ХҮІ зуун)
25. 1740-өөд оны Зүүнгарын хаан ширээний төлөөх тэмцэл
26. Дөрвөд баядууд нүүж, дүрвэхээр хэлэлцэж Манжид дагаар орсон тухай
27. Дөрвөд, баядын зарим ноёд урваж одсон нь
28. Дөрвөдүүд дагаар ороод нутаг олтол энд тэнд нүүж зовсон тухай
29. Торгууд Шэрэн тайж урваж Халимагт очсон
30. Зүүнгарыг эзлэх Манжийн их цэргийн бүтцийн тухай
31. Амарсанаа урвасан тухай болон нэхэж очсон цэргүүдтэй хэрхэн харьцсан
32. Ховд хотын үүсэл, амбаны тухай
33. Дөрвөдийн зургаан тайж оргосон нь
34. Дөрвөдүүд Улаангомд суурьшиж, тариа тарин амар жаргасан тухай

Тус зохиолд бусад сурвалжийн мэдээтэй харьцуулах, бусад мэдээг нөхөх, нөхвөрлөх олон арван үнэтэй мэдээ байна. Тухайлбал, ХҮІ зууны Ойрадын бүтэц, бүрэлдхүүний тухай "Орын ганц модны олон их отог бурад, жалайд, шарас, галзад, урад эд нэг нь буй. Дөрвөн омог хойд гэгч их мянган, алаг гулз, үл түмэн, цагаан туг энэ дөрвөн. Дээр нь Гүрүд, Зултус, бөнөнүүд, эзнэйд, хөтөч нар, дурмуд эд нэг нь энэ буй. Баруун дөрвөд, их дөрвөд, бага дөрвөд, хангал, хэрэс, Галзандоржийн баяазуур, өөлд, урианхай, Алтан нуур, захчин, буучин, Хасаг шар, Дугар зайсан эд нэг нь энэ буй. Хошууд, Торгууд, Баруун отог, дөчин отог эд нэг нь энэ буй" [Дөрвөн Ойрадын..., 1976, &16b] гэсэн мэдээ үнэ цэнэтэй мэдээ юм. Тэр үеийн Ойрадын бүтэц бүрэлдхүүн, засаг захиргааны хуваарилалтын мэдээ тэр бүр тааралддаггүй.

Зохиогч тодорхойгүй "Дөрвөн Ойрадын түүх тууж" сурвалж зохиолд гарах мэдээнүүдийг нарийн нягталж, Монголын түүхийн бусад сурвалжууд болон Манж Чин улсын албан түүхийн баримт материалтай тулган үзэх, тус сурвалжийг түүхийн судалгаанд өргөнөөр оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

БНМАУ-ын түүх. II боть. УБ., 1968.

1. "Дөрвөн Ойрадын түүх тууж" ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн сан хөмрөг. 853/1/

2. "Дөрвөн Ойрадын намтар" ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн сан хөмрөг. 1071

3. "Дөрвөн Ойрадын намтар түүх" УТНС. ГБС.

Дөрвөн Ойрадын түүх тууж. (латин галиг) Тод үсгийн дурсгалууд.

Х.Лувсанбалдан. Corpus Scriptorum Mongolorum. Том XIX. УБ. 1976

Тод үсгийн дурсгалууд. эмхтгэж, оршил тайлбар бичсэн Х.Лувсанбалдан.

Corpus Scriptorum Mongolorum. Том XIX. УБ. 1976.

Ойрад түүхэн сурвалж бичгүүд. эмх. Бадай, Эрдэнэ, Алтан-Оргил. Хөх хот. 1985

Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд. I дэвтэр. эмхтгэж, тайлбарласан На.Сүхбаатар. УБ., 2001.

Пэрлээ Х. Хувьсгалаас өмнөх үеийн Монголын түүх бичлэгийн асуудалд. УБ., 1960 .

SUMMARY

Na.Sykhbaatar

Some issues on the study of historical source  
"Dörben oyirad-un teüke tuYuji"

It appears, the anonymous historical source entitled "Dörben oyirad-un teüke tuYuji", was created by a lama in Durbet aimag of Khovd's periphery-province, in 1770.

It is a valuable and prerequisite historical source for Four Oirats' history, notably, for Zuungar's and Durbet history.